

УЛС ТӨР,
ЭДИЙН ЗАСАГ

МАХН-ЫН ТӨВ ХОРООНЫ V БҮГД
ХУРАЛ, ГАДААД БОДЛОГО

ШҮҮМЖЛЭЛТ ТЭМДЭГЛЭЛ

Х. Олзвой

БНМАУ-ын тусгаар тогтнолыг бэхжүүлэх, олон улсын нэр хүндийг өргөх, ард түмний аж байдлыг сайжруулах, нийгэм-эдийн засгийн дэвшлийг хангахын төлөө хийсэн урт удаан жилийн тэмцэлд тус улсын энх тайванч, найрамдал нөхөрлөлийг эрхэмлэгч гадаад бодлого чухал хувь нэмэр оруулсан билээ. Өнөөдөр Монгол улс дэлхийн 100 гаруй оронтой хэвийн, найрсаг харилцаа хөгжүүлж, НҮБ, олон улсын бусад байгууллагад бүрэн эрхт гишүүний эрхээ эдэлж, нийгмийн дэвшлийн замаар итгэлтэй хөгжиж байгаа нь үүний нэг илрэл юм. Монголын хил хязгаар олон улсын хууль зүйн үндсэн дээр тодорхойлогдсон бөгөөд тус улс ямар нэг маргаант асуудал, бүс нутгийн мөргөлдөөнд татагдан ороогүйгээр барахгүй, харин ч зэвсэг хураах, аюулгүй байдлыг бэхжүүлэх хэрэгт идэвхтэй оролцож санал, санаачилга дэвшүүлэн ажиллаж байгаа нь гадаад бодлогын үйл ажиллагааны бас нэг амжилт мөн.

Энэ бүхнийг тэмдэглэхийн хамт 1988 оны арванхоёрдугаар сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал Монгол орны нийгэм улс төрийн амьдралд чухал эргэлтийн эхэн болсныг онцлон дурдвал зохино. Энэ бүгд хурал шинэчлэлт, өөрчлөлтийн бодлогын цар хүрээг тэлж, нам, улсын амьдралын бүх салбарт хэрэгжүүлэх өргөн программ дэвшүүлсэн юм. Бүгд хурал манай орны гадаад бодлогын үйл ажиллагааг өндрөөр үнэлэхийн хамт анх удаа түүний дутагдал, доголдлыг илэн далангүй шүүмжлэн зааж «БНМАУ-ын гадаад үйл ажиллагааг өөрчлөн байгуулалтын үзэл санааны дагуу улам боловсронгуй болгох нь зүйтэй»¹ гэж үзэв.

Бүгд хуралд оруулж хэлэлцүүлсэн «Намын зохион байгуулалт, үзэл суртлын ажлыг сайжруулах шинэ зорилт»-ын тухай илтгэлд гадаад бодлогын үйл ажиллагааны үндсэн дутагдлуудад доорх зүйлийг хамааруулан дурдсан. Үүнд:

1. Улс орны дотоод амьдралын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гадаад харилцааны өргөн боломжийг тэр бүр дүүрэн ашиглаж чадаагүй.

2. Гадаад харилцааны ажил тунхаглах шинжтэй, улс орны эрэлт хэрэгцээ, бодит боломжтой төдийлэн нийцдэггүй.

3. Олон улсын байдал болон гадаад харилцааны асуудалд нарийн судалгаа, дүн шинжилгээтэй хандах явдал дутагдалтай.

4. Гадаад улс төр, гадаад эдийн засгийн бодлогын харилцан шүтэлцээ, цогц байдлыг зөв хослуулах явдал дутагдалтай.

5. Арга барилын хувьд захиран тушаах хэлбэр бусад салбарын адил ноёрхсон, өргөн олон түмний санаа бодлыг судалж сонсох ажил дутмаг, ил тод байдал хязгаарлагдмал явж иржээ.

Бүгд хурал ийнхүү зарчмын дүгнэлт хийгээд зогсоогүй гадаад бодлогын үйл ажиллагааг боловсронгуй болгоход ач холбогдолтой дараах чиглэлийг тодорхойлсон юм. Тухайлбал:

— сансар-цөмийн эрин үед улс гүрнүүд хамтдаа аж төрж, энх амгалан оршихоос өөр арга замгүй;

— үзэл суртал, бусад ялгааг шалтаг болгохгүйгээр энх тайвнаар зэрэгцэн орших, итгэлцэх, сайн хөрш байх, харилцан ашигтай хамтын ажиллагаа тогтоон хөгжүүлэх нь цаг үеийн бодит хандлага мөн;

— социализм байгуулах нийтлэг зорилгод хүрэх арга зам улс бүрийн өвөрмөц байдал, үндэсний орлогоос шалтгаалан янз бүр байж болох бөгөөд социалист орнууд дахь өөрчлөн байгуулалтын явц гүнзгийрэхийн хэрээр тэдгээрийн хамтын ажиллагааны харилцаанд агуулга, хэлбэрийн хувьд зарчмын өөрчлөлт гарч байна;

— БНМАУ бол хөгжиж байгаа социалист орнуудын нэг мөн бөгөөд тулгамдсан зорилтоо шийдвэрлэхэд энэ боломжоо ашиглаж идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь чухал юм.

МАХН-ын дээрх заалт, чиглэлийн үндсэн дээр БНМАУ-ын гадаад бодлого, гадаад харилцааны байгууллагуудын үйл ажиллагаанд нухацтай дүгнэлт хийж, ойрын болон хэтийн зорилтоо зөв тодорхойлж арга барилдаа шинэчлэлт өөрчлөлт хийх цаг ирлээ. Эдгээр чиглэл, дүгнэлтийг хийснээрээ МАХН дэлхийн хөгжлийн төлөв, өөрийн орны хөгжлийн бодит байдалд суурилсан бөгөөд үндэсний эрх ашигт нийцсэн зөв зүйтэй шийдвэрийг зоримог гаргадгаа дахин харууллаа.

Гадаад бодлогын салбар дахь дутагдал доголдол нь манай орны социалист байгуулалтын онол, практикийн зарим гажуудлаас эх үүсвэртэйгээс гадна гадаад бодлогын үйл ажиллагааг шууд хариуцсан байгууллагуудын ажлын арга барилтай холбоотой байсан нь мэдээж юм.

Ардын хувьсгалын ялалтын эхний өдрүүдээс Монгол улс гадаадын бүх орон, үндэстэнтэй найрсаг харилцаа тогтоон худалдаа арилжааг хөгжүүлэхийг эрмэлзэж байсны тодорхой баримт нь Монгол ард улсын тусгаар тогтнолыг тунхагласан тухай гадаадын бүх улсад хандан гаргасан 1921 оны есдүгээр сарын 14-ний уриалга юм.² Монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч найрамдлын гараа сунгасан анхны орон бол Зөвлөлт Орос байлаа. Харин тэр үеийн империалист гүрнүүд хөгжлийн шинэ зам сонгосон Монголын ард түмний хүсэл эрмэлзлийг үл ойшоох бодлого баримталж байлаа. Ийм нөхцөлд 1928 оны 12 дугаар сард хуралдсан Улсын тавдугаар их хурлаас... гадаадын эзэрхэг түрэмгий улсуудтай... харилцахыг хүсэхгүй ба хэрэв тэдгээр улсуудаас харилцахыг сайтар хянан болгоомжилж...»³ байна гэж дүгнэснээс хойш хэсэг хугацаанд энэ чиглэл хэвээр үр гэлжилсэн байна. Монгол орныг ганцаардуулах, үл тоомсорлох гэсэн империалист хүчний оролдлого дэлхийн хоёрдугаар дайны дараа балран унаж, БНМАУ-ыг хүлээн зөвшөөрч албан ёсны харилцаа тогтоох үйл явц аажмаар эхэлсэн юм.

БНМАУ-ын гадаад харилцааны хөгжлийн шинэ үе эхэлсэн 1940 оод оны сүүлч, 1950-иад онд янз бүрийн учир шалтгааны улмаас хэт үзэл сурталдах, нийгэм, ангийн ялгааг онцгойлж үзэх үзэл баримтлал цаашид лавширч улмаар ажлын арга барил, гадаад бодлогын чиглэл болж хэлбэршсэн байна. Манай орны гадаад улс төрийн байдлыг бэхжүүлэхэд ач холбогдолтой зарим үйл явдал, тухайлбал Ази,

Африкийн орнуудын Бандунгийн бага хуралд оролцоогүй хийгээд Курдистаны асуудал гэгчийг НҮБ-д хөндөн тавьсан зэрэг үндэсний эрх ашгийг харгалзаагүй алхмууд хийгджээ.

Үзэл суртлын маргааныг хэт дөвийлгөн сөргөлдөх, тооны хойноос хөөцөлдөөд нэгэнт тогтоосон албан ёсны харилцаагаа цаашид хөгжүүлэх арга зам сүвэгчлэхгүй, хэлбэрдэх арга барил гадаад харилцааны ажилд аажмаар бүрэлдэн тогтсон юм. Энэ нь гадаад бодлогын үйл ажиллагаанд хүндрэл учруулж, үр ашгийг нь багасгахад нөлөөлсөн нь мэдээж.

Улс төр, үзэл суртлын салбар дахь зорилтод илүү ач холбогдол өгч, дэлхий нийтийн чанартай нарийн асуудлуудыг шийдвэрлэхэд «томоохон» хувь нэмэр оруулах чиглэлийг сонгосон нь гадаад бодлогын үйл ажиллагаа улс орны нийгэм эдийн засгийн зорилтуудаас хөндийрч, гадаад улс төр болон эдийн засгийн бодлого зааглагдан холдоход хүргэсэн байна. Гадаад худалдаа, эдийн засгийн харилцааны жинхэнэ үр ашиг, унац өгөөжийг тооцоолон бодитой үнэлэлт, дүгнэлт өгч байхын оронд хэт гоёчилсон тоо баримтаар нүд хуурах явдал ажиглагдсаар байлаа. Гадаадаас авах зээл тусламжийн бодлого ч үзэл суртлын баримтлалд хүлэгдэж, дэлхийн санхүү, эдийн засгийн харилцааны боломжийг дүүрэн ашиглаж чадахгүй байна.

НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудад оролцох, тэдний хүрээнд санал, санаачилга дэвшүүлэн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ч дээрх үзэл баримтлал ихээхэн нөлөөлснөөс болж ухуулгын хоосон тунхаглалд хэтэрхий татагдан орсонд дүгнэлт хийх ёстой. Хөгжиж байгаа бараг бүх орныг нэгтгэсэн «77-гийн бүлэг»-т элсээгүй, Азийн орнуудын бүлгэмд ёс төдий оролцож байгааг зөвтгөх үндэсгүй юм.

НҮБ-д улс орныхоо хөгжлийн бодит тоо баримтыг мэдээлж, хөгжиж байгаа эдийн засагтай, далайд гарцгүй жижигхэн орон гэдгээ зоригтой тавьж байгаагүй нь тус байгууллагын системээс үзүүлж буй техник тусламжийг дутуу ашиглахад нөлөөлсөн ч байж болох юм.

Гадаад бодлогын үйл ажиллагааны чиглэл, алхмуудыг хязгаарлагдмал хүрээнд шийдвэрлэх барил ноёрхож ирснээс ард түмний оролцоо багасч, шинжлэх ухааны үндэслэл, судалгаа муутай шийдвэр гарахад хүрч байна. Эрдэм шинжилгээний байгууллагууд, тухайлбал ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэн түүхийн суурь судалгаанд хэт төвлөрч гадаад бодлого, ялангуяа Ази, Алс Дорнодод явуулах бодлогын тулгамдсан зорилтыг шийдвэрлэх арга замыг үндэслэлтэй тодорхойлох, үндэсний эрх ашигт нийцсэн бодитой алхам төлөвлөн хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах, санамж боловсруулах талаар дутагдалтай явж ирснийг дурдах хэрэгтэй.

БНМАУ бол Төв Азид оршдог, хүн ардын маань зан заншил, уламжлал, соёл Ази тивийн олон түмэнтэй түүхэн холбоотой билээ. Ийм ч учраас тус тивийн ард түмнүүдийн энх тайван, аюулгүй байдал, хөгжлийн асуудал манай хувьд онцгой ач холбогдолтой нь мэдээж. Чухамхүү үүнийг үндэс болгож Азийн нүүр царайтай, азичуудын өмнө тулгарсан зорилтуудыг шийдвэрлэхэд дөхөм үзүүлэхэд чиглэсэн бодлого баримтлах нь манай орны олон улсын нэр хүндийг улам өргөх нэг зам юм. Манай намын их хурлуудын баримт бичгийг үзэхэд 1981 онд хуралдсан МАХН-ын XVIII их хурал анх удаа Азийн чиглэлд явуулах бодлогыг онцлон дэвшүүлж, Ази, Номхон далайн

бүс нутгийн орнуудын харилцаанд хүч үл хэрэглэх, харилцан үл довтлох конвенц байгуулах санал дэвшүүлсэн байна. Энэ саналаа тайлбарлах урагшлуулах талаар өнгөрсөн хугацаанд багагүй ажилласан боловч зөвхөн социалист цөөн орны санал санаачилгатай холбон «үндэслэх»-ийг оролдож ирснээс биш, Ази тив дэх маргаант асуудлуудыг шийдвэрлэх, харилцан үл довтлох механизм байгуулах нэг чухал нөхцөл-итгэлцлийн уур амьсгал бий болгох гэх мэт практикт зорилтуудтай холбон тавьж чадаагүй юм. Нөгөөтэйгүүр, бусад улс, олон нийтийн санаа бодол, учир шалтгааныг судлан нэгтгэх, саналынхаа гол гогцоо асуудлуудыг онолын өндөр түвшинд боловсруулж хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох талаар олигтой ажил зохиосонгүй.

Азийн чиглэлд явуулж буй манай бодлогын өөр нэг дутагдал бол мөнөөх үзэл суртлын болон ангийн өрөөсгөл хандлагаас чөлөөлөгдөөгүй байгаа явдал юм. Намын их хурлаас дэвшүүлсэн санал, санаа чилгуудыг хэрэгжүүлэх ажлыг юуны өмнө «дэвшилт хүчний» дунд зохиосноор хязгаарлаж, бусадтай ажиллахаас цэрвэсээр байгаа нь үүний баримт мөн. Энэ тивийн орнуудтай тогтоосон улс төрийн харилцаагаа худалдаа-эдийн засгийн хэлхээ холбоогоор бэхжүүлэхэд төдийлөн анхаарахгүй байсан нь улс төрийн зорилтоо хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж ирэв.

Олон нийтийн байгууллагуудаас Азийн зүгт зохиож байгаа ажил хязгаарлагдмал, хоорондоо уялдаа холбоогүй, ёслолын шинж чанартай байгааг ч хэлэх ёстой.

Азийн социалист орнууд, түүнчлэн Энэтхэг, Япон зэрэг улстай БНМАУ нэлээд өргөн харилцаатай бөгөөд цаашид ч энэ нь өргөжин хөгжих төлөвтэй байна. Гэвч нөлөө, эдийн засгийн бололцоо, нөхцөл нь түргэн өсч байгаа Зүүн Өмнөд Азийн улсуудын нийгэмлэг (АСЕАН) ийн гишүүд зэрэг Азийн бусад орнуудтай холбоо, хэлхээгээ өргөтгөх талаар хийсэн алхам төдийлэн үгүй байна.

БНМАУ 1962 онд Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын бүрэн эрхт гишүүн болсон боловч түүний өргөн бололцоог дүүрэн ашиглаагүй өнөөг хүрч байгааг өөрчлөх шаардлагатай. Азийн хөгжлийн банкны үйл ажиллагааг судлан зээл, техник тусламж авах бодлого боловсруулмаар байна.

Дэлхийн эдийн засгийн хуваарьт БНМАУ-ын оролцоог өргөтгөж, орчин үеийн шинжлэх ухааны тэргүүлэх салбарт амжилт олсон өндөр хөгжилтэй болон үйлдвэржиж буй орнуудтай улс орны хэрэгцээ, шаардлагын дагуу харилцаа хөгжүүлэх, хамтын үйлдвэр байгуулах, хөгжлийн туршлага, арга барилаас нь суралцах зорилт дэвшигдэж байна. Тэгэхдээ газар нутгийн талаар ойр, түүнчлэн уламжлалт харилцаатай орнууд, Азийн улсуудыг түлхүү анхаарах нь мэдээж юм. Англи, ХБНГУ, Итали, Франц зэрэг орон тэдний зарим пүүс БНМАУ-тай эдийн засгийн салбарт хамтран ажиллах, хамтарсан үйлдвэр байгуулах сонирхол илэрхийлж байгааг нухацтай, шуурхай судалж ажиллах ёстой. Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгтэй албан ёсны харилцаа тогтоож, хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулахаар саяхан шийдвэрлэсэн нь зүйтэй алхам болов.

Хүн төрөлхтний өмнө тулгарсан нэн чухал зорилтууд, тухайлбал олон улсын аюулгүй байдлыг адил тэгшээр хангах, хүрээлэн байгаа орчныг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд оруулах улс орны хувь нэмрийг нарийн бодож боловсруулах, санал, санаачилга дэвшүүлэх нь чухал байна. Өнөөгийн олон улсын харилцааны нааштай өөрч-

лөлт, шинэ сэтгэлгээний үзэл санаа, улсын эдийн засаг, хөгжлийн шаардлага, төлөвийг харгалзан БНМАУ-ын аюулгүй байдлын чиг баримтлалыг ч эргэн харж, үндэслэлтэй боловсруулах цаг болсон гэж үзэж байна. Улс орны аюулгүй байдлыг улс төрийн аргаар бэхжүүлэх, цэрэг зэвсгээ хорогдуулах боломж, нөхцөл нэмэгдэж байгааг анхаарах хэрэгтэй юм.

Ийнхүү гадаад бодлогын үйл ажиллагаа, арга барилдаа өөрчлөлт шинэчлэлийн үзэл санааны дагуу зарчимт дүн шинжилгээ хийж хуучин сэтгэлгээг зоригтой таягдан хаяхад гадаад харилцааны салбарт ажиллаж байгаа бүх шатны боловсон хүчин, дипломатууд, мэргэжилтнүүдийн санаачилгатай, бие даасан бүтээлч ажил туйлын чухал юм

Орчин үеийн олон улсын харилцааны тулгуур асуудлуудыг нарийн мэддэг, дипломатын урлаг, үр дүнг сайн эзэмшсэн, эх орон, ард түмнийхээ түүх, соёлын уламжлал, хөгжлийн асуудлуудыг гүнзгий судалсан, гадаад хэлний өргөн мэдлэгтэй мэргэжилтэн, дипломат ажилтнуудын эгнээг өргөтгөхөд боловсон хүчний чиглэсэн зорилготой программ боловсруулан мөрдөж, тэднийг шилж сонгох, давтан сургах, дадлагажуулахад гоц анхаармаар байна. Гадаад бодлогын салбар дахь шинэчлэл, өөрчлөлтийн нэг чухал чиглэл чухамхүү үүнд оршиж байна. Сэтгэлгээ, арга барилын шинэчлэлээс ажлын эцсийн үр дүн, тодруулбал манай улсын гадаад харилцааны үр өгөөж хамаарах нь дамжиггүй.

МАХН-ын Төв Хорооны тавдугаар (1988 он) бүгд хурлаас хойшхи богинохон хугацаанд гадаад улс төрийн болон эдийн засгийн харилцааг шинэчлэх, үр өгөөжийг нь дээшлүүлэх, цаг үеийн шаардлагад нийцүүлэх талаар холбогдох байгууллагууд тодорхой ажил хийж эхэлсэн бөгөөд гагцхүү тэр үйлсээ туйлд нь хүргэх эрхэм зорилт үлдээд байгааг эцэст тэмдэглэе.

1. Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны V бүгд хурал, Улаанбаатар, 1988, 23 дахь тал
2. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл, 1 боть, УБ, 1961 он, 7—8 дахь тал
3. «БНМАУ-ын их, бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхагууд», Улсын хэвлэлийн газар, УБ., 1956, 99 дүгээр тал

**ОЛОН УЛСЫН КОММУНИСТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮҮХ, ОРЧИН ҮЕИЙН
АСУУДЛААР БНХАУ-д ХИЙГДЭЖ БУЙ
СУДАЛГААНЫ АСУУДАЛД**

Ш. Эрдэнэчимэг

Олон улсын коммунист хөдөлгөөний дотор улс төрийн шинэ сэтгэлгээ бүрэлдэж байгаа өнөөдрийн нөхцөлд ах дүү намууд бие биеэ харилцан хүндэтгэх зарчимд тулгуурлан өөр өөрсдийн үзэл бодлоо өргөнөөр байнга солилцон харьцуулан үзэх явдал чухал болж байна.